



# Элсэлтийн журамд оруулсан шинэчлэлүүд

## Гэр бүлүүдэд зориулсан мэдээлэл

### Журамд ямар шинэчлэлүүд хийгдсэн бэ?

Цэцэрлэг (Kindergarten) болон сургуулийн 12-р анги хүртэлх (Year 12) сургуулийн элсэлтийн журамд дараах өөрчлөлтүүд хийгдсэн бөгөөд эдгээрийг 2026 оны 1-р улирлаас эхлэн бүх төрлийн сургуулиуд мөрдөнө.

#### Орон нутгийн бус элсэлтэд хийгдсэн шинэчлэлүүд

2025 онд бид суралцах болон сайн сайхан байдлын тодорхой хэрэгцээ бүхий сурагчид, тухайн сургуульд одоогоор сурч байгаа сурагчдын ах дүү нар, мөн сургуулийн албан хаагчдын хүүхдүүдийн гаргасан орон нутгийн бус элсэлтийн өргөдлийг нэн тэргүүн ээлжинд авч үзэх шалгуурыг нэвтрүүлсэн болно.

2026 онд орон нутгийн бус элсэлтийг дараах тохиолдлуудад мөн тэргүүн ээлжинд авч үзнэ:

- Соёл, гэр бүл болон kinship connections-г хүндэтгэн, Абориген болон Торрес хоолойн арлын гаралтай сурагчдын элсэлт
- NSW мужийн улсын сургуультай нэг дор байрлах төрийн өмчит цэцэрлэгт хамрагдсан, тус Kindergarten-аас элсэгч хүүхдүүд

#### Зэвсэгт хүчний албан хаагчдын хүүхдүүдэд илүү уян хатан боломж олгох нь

Зэвсэгт хүчний албан хаагчдын нүүн шилжих үе болон орон сууцжих хугацаанд, тэдний хүүхдүүдийн сургуулийн элсэлтэд тавигдах шаардлагыг илүү уян хатан болгон уг элсэлтийн журмыг шинэчилж байгаа болно.

#### Абориген болон Торрес хоолойн арлын kinship холбоог хүлээн зөвшөөрөх нь

Абориген болон Торресийн хоолойн арлын гаралтай сурагчдыг kinship connections, соёлын аюулгүй байдал, Абориген хэлний хөтөлбөрт хамрагдах боломж, мөн түүнчлэн "Sorry Business" зэрэг соёлын үүрэг хариуцлагыг нь харгалзан үзэж тэдгээр сурагчдын элсэх өргөдлийг хянахад нь сургуулиудад илүү өргөн боломж олгоно.

#### Онцгой эмзэг бүлгийн сурагчдыг тасралтгүй сургалтаар хангах нь

Цагдаагийн хяналтад байгаа сурагчид, мөн түүнчлэн өсвөр үеийнхний хорих болон хамгаалах төвөөс сургууль руу шилжиж буй сурагчдад зориулсан тусгай журмыг хэрэгжүүлж ийм төрлийн сурагчдын орон нутгийн элсэлтийн өргөдлийг одооноос эхлэн 2 сургалтын өдрийн дотор боловсруулна.

## Түгээмэл асуултууд

### Эдгээр өөрчлөлтүүд миний хүүхдэд хамаарах уу?

2026 оны NSW мужийн улсын сургуулийн элсэлтийн журмын уг өөрчлөлт танд дараах тохиолдолд хамаарах болно:

- Таны хүүхэд kinship шинж чанар, хэл болон соёлын тал дээр Абориген болон Торрес хоолойн арлын гаралтай бол
- Таны хүүхэд асран хамгаалагч гэр бүлд амьдардаг, цагдаагийн хяналтанд байдаг, эсвэл өсвөр үеийнхний хорих болон хамгаалах төвөөс сургууль руу шилжиж байгаа бол
- Хүүхдийн эцэг эхийн аль нэг нь зэвсэгт хүчинд алба хаасан эсвэл одоо алба хааж байгаа бөгөөд Австралийн Зэвсэгт Хүчний ажил үүргийн шугамаар шилжилт, нүүлгэн байршуулалтад хамрагдаж байгаа бол

### Бүх сургууль эдгээр өөрчлөлтийг заавал хэрэгжүүлэх үү?

Элсэлтийн сул орон тоо байгаа эсэхээс хамааран, сургуулиуд 2026 оны 1-р улиралд элсэж буй орон нутгийн бус элсэлтийн сурагчдын хувьд эдгээр өөрчлөлтүүдийг заавал хэрэгжүүлнэ.

Орон нутгийн бус элсэлтийн журмын энэхүү өөрчлөлт нь тусгай ангилал, тусгай хөтөлбөрт төрөлжсөн сургуулиудын элсэлтийн шаардлагад нөлөөлөхгүй. Үүнд: бүрэн сонгон шалгаруулалтын сургууль, тусгай зориулалтын сургууль (schools for specific purposes (SSPs)), зайны сургалтын сургууль, элсэлтийн тодорхой шаардлага бүхий анги хөтөлбөртэй сургуулиуд (жишээлбэл: сонгоны анги, спортын болон урлагийн төрөлжсөн хөтөлбөрүүд) багтана. Эдгээр сургуулиуд нь өөрсдийн тусгай элсэлтийн журам, шалгуур, үнэлгээтэй бөгөөд цаашид ч өөрсдийн одоогийн элсэлтийн журмыг дагаж мөрдөх болно.

Хөвгүүдийн эсвэл охидын сургуулиуд нь элсэлт хүсэлт гаргаж буй хүүхэд тухайн сургуулийн хүйсийн шаардлагад нийцэж байвал эдгээр өөрчлөлтийг дагаж мөрдөх ёстой. Эдгээр өөрчлөлт таны хүүхдийн элсэлтэд хэрхэн нөлөөлөх талаар тодруулахыг хүсвэл тухайн сургуультай шууд холбогдоно уу.

### Хэрэв миний хүүхэд шинэчлэгдсэн шалгуурыг хангаж байгаа бол орон нутгийн бус элсэлтийн өргөдлийг сургууль автоматаар хүлээн зөвшөөрөх үү?

Эдгээр өөрчлөлтүүд нь таны хүүхдийг орон нутгийн бус улсын сургуульд элсүүлэх нь баталгаатай болно гэсэн үг биш юм. Орон нутгийн болон орон нутгийн бус элсэлт авч буй сургуулиуд орон тоо байгаа эсэхээс хамаарч таны өргөдлийг хэлэлцэн авч үзнэ. Харин орон нутгийн бус элсэлтийн боломж хязгаарлагдмал сургуулиуд дараах тохиолдолд орон нутгийн бус элсэх хүсэлтүүдийг тэргүүн ээлжинд авч үзнэ:

- суралцах болон сайн сайхан байдлын хэрэгцээтэй, уг хэрэгцээ нь өөрт тохирсон сургалт болон нэмэлт боловсролын дэмжлэг шаардлагатай сурагчид. Үүнд:
  - Абориген болон Торресын хоолойн арлын уугуул сурагчдын kinship connections, соёл, гэр бүлийн холбоотой байдал
  - Хөгжлийн бэрхшээл
  - Өсөлт хөгжлийн насанд яваа
  - Гэмтэл, травма
  - Хүүхэд хамгааллын асуудал бүхий
  - Эмнэлгийн болон хувь хүний хэрэгцээ, нөхцөл байдлын онцлог

- Одоогоор тухайн сургуульд суралцаж байгаа, эсвэл тухайн сургуулийн туслах ангид одоогоор суралцаж буй сурагчийн ах дүү байвал тухайн өргөдлийг тэргүүнд үзнэ.
- тухайн сургуультай нэг дор байрлах төрийн өмчит цэцэрлэгт хамрагдсан, тус Kindergarten-аас элсэгч хүүхдүүд

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл холбогдох сургуультай холбогдоно уу.

### Энэ нь цаашид зөвхөн нэн тэргүүний шалгуурыг хангасан сурагчдыг л орон нутгийн бус элсэлтээр авах болно гэсэн үг үү?

Үгүй. Хүүхэд тань тухайн сургуулийн элсэлтийн шаардлагыг хангасан бөгөөд сургуульд элсэлтийн орон тоо байгаа тохиолдолд эцэг эхчүүд хүүхдээ ямар ч улсын сургуульд элсүүлэхээр өргөдөл гаргаж болно. Орон нутгийн бус элсэлтийн хязгаарлагдсан боломж бүхий сургуулиуд элсэлтийн өргөдөл хүлээн авахдаа орон нутгийн бус элсэлтийн шинэчлэгдсэн шалгуураар эрэмбэлж, харгалзан үзэх ёстой.

### Манай хүүхдийн орон нутгийн бус элсэлтийн өргөдлийг урд нь зөвшөөрөөгүй. Одоо манай хүүхэд шинэчлэгдсэн шалгуурыг хангаж байна. Би дахин өргөдөл гаргаж болох уу?

Тийм. 2026 онд та хүүхдээ орон нутгийн бус сургуульд элсүүлэхээр өргөдөл гаргаад татгалзсан шийдвэр авсан бол, хүүхэд тань шинэчлэгдсэн орон нутгийн бус элсэлтийн шалгуурыг хангасан тохиолдолд дахин өргөдөл гаргах боломжтой. “Хүүхдийнхээ элссэн сургуулийг хэрхэн өөрчлөх вэ?” гэсэн гарчигт дурдсан алхмуудыг дагаж мөрдөнө үү.

### Би Year 6-аас Year 7-р Ангид шилжилт Бүртгүүлэх Хүсэлт (Expression of Interest (EOI))-ээ өгсөн. Хүүхдээ элсүүлсэн сургуулиа одоо өөрчилж болох уу?

Тийм. Хэрэв таны хүүхэд шинэчлэгдсэн орон нутгийн бус элсэлтийн шалгуурыг хангаж байгаа бол та Year 6-аас Year 7-р ангид шилжих EOI-г аль хэдийн гаргасан байсан ч гэсэн хүссэн орон нутгийн бус сургуульдаа шинэ өргөдөл гаргах боломжтой. “Хүүхдээ аль хэдийн сургуульд элсүүлсэн бол өөр сургуульд дахин хэрхэн элсэх вэ?” гэсэн доорх хэсэгт заасан алхмуудыг дагаж мөрдөнө үү.

### Хүүхдээ аль хэдийн сургуульд элсүүлсэн бол өөр сургуульд дахин хэрхэн элсэх вэ?

Хэрэв эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ орон нутгийн бус сургуульд элсүүлэхийг хүсвэл, элсэлтийг нь өөрчлөхдөө дараах алхмуудыг дагаж мөрдөнө:

#### Онлайн элсэлтийн өргөдөл

1. Элсүүлэхийг хүссэн улсын сургуулийнхаа цахим хуудсан дэх цэснээс элсэлт (enrolment) гэсэн хэсэгт дарна.
2. Элсэлтийн вэб хуудсан дээр хэрхэн элсэх (how to enrol) гарчиг дор байрлах онлайн элсэлтийн өргөдлийн холбоос (online enrolment application) дээр дарж өргөдлөө бөглөнө.
3. Хүүхдээ элсүүлэх онлайн өргөдлөө илгээсний дараа сургууль танд элсэлтийг хүлээн зөвшөөрсөн урилга явуулсан бол та үүнийг 14 хоногийн дотор зөвшөөрсөн байх шаардлагатай.
4. Хэрэв таны өргөдлийг сургууль зөвшөөрсөн бол, хүүхдийнхээ өмнө нь элссэн байсан сургуультай холбогдож, элсэлтийн бүртгэлийг нь цуцлуулах хэрэгтэй.

## Цаасан маягтаар өргөдөл гаргах

1. Орон нутгийн бус улсын сургуультай холбогдож таны хүүхдийг элсүүлэх боломжтой эсэхийг олж мэдэх хэрэгтэй.
2. Хэрэв сургууль хүүхдийг тань элсүүлэх боломжтой бол, сургууль танд шинэ цаасан маягтын өргөдлийг өгөх ба та маягтыг бөглөнө.
3. Элсэлтийн өргөдлөө сургуулийн захиргаанд өгсний дараа, сургууль танд өргөдлийг хүлээн зөвшөөрсөн урилга явуулсан бол та үүнийг 14 хоногийн дотор зөвшөөрсөн байх шаардлагатай.
4. Хэрэв таны өргөдлийг сургууль зөвшөөрсөн бол, хүүхдийнхээ өмнө нь элссэн байсан сургуультай холбогдож, элсэлтийн бүртгэлийг нь цуцлуулах хэрэгтэй.

## Хэрэв надад байнгын оршин суух хаяг эсвэл шаардлагатай бичиг баримт байхгүй бол яах вэ?

Хаягийн баталгаагүй байсан ч сурагчийг тодорхой нөхцөл байдалд элсүүлэх боломжтой байдаг. Үүнд: соёлын онцгой нөхцөл байдал, зэвсэгт хүчний албан хаагчдын хүүхдүүд, асран хамгаалагч гэр бүлд амьдарч буй хүүхэд өсвөр насныхан, батлан даалтад байгаа эсвэл өсвөр үеийнхний хорих болон хамгаалах төвөөс сургууль руу шилжиж байгаа сурагчид зэрэг орно. Гэхдээ эдгээр нөхцөл байдлууд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй гэдгийг анхаарна уу. Хэрэв эдгээр нөхцөл байдал танд хамааралтай гэж үзэж байвал, тухайн сургуультай холбогдон дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

## 2025 оны элсэлтийн бодлого, журамд орсон өөрчлөлтүүд хүчин төгөлдөр хэвээр үү?

Тийм. 2025 онд оруулсан өөрчлөлтүүд 2026 оны элсэлтэд мөн хүчинтэй хэвээр байна. Үүнд дараах багтана:

- Түр оршин суух визтэй бүх сурагчид тухайн оршин суугаа хаягийн дагуу харьяалагдах орон нутгийн улсын сургуульд элсэх боломжтой.
- Улсын сургуулиуд тухайн сургуульд суралцаж буй ах дүү сурагчдын орон нутгийн бус элсэлтэд давуу эрхтэйгээр авч үзнэ. Тухайн сургуулийн туслах ангид одоогоор суралцаж буй ах дүү байвал тухайн өргөдлийг тэргүүнд үзнэ.
- Улсын сургуулийн албан хаагчдын хүүхдийг орон нутгийн бус элсэлтийн журмаар авч үзэх боломжтой.

Эдгээр өөрчлөлтийн талаар нэмэлт мэдээлэл авах, эсвэл таны хүүхдэд хамаарах эсэхийг шалгахыг хүсвэл тухайн сургуультай холбогдоно уу.

## Би хаанаас нэмэлт мэдээлэлтэй танилцах вэ?

**Элсэлттэй холбоотой асуулт байвал, элсэх сургуультай шууд холбогдоно уу. Тус сургуулийн холбогдох мэдээллийг дараах хаягаас олж харах боломжтой:**

[education.nsw.gov.au/find-a-public-school](https://education.nsw.gov.au/find-a-public-school)

**NSW мужийн улсын сургуульд хэрхэн элсэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хаягаар орж танилцана уу:**

[education.nsw.gov.au/enrolment](https://education.nsw.gov.au/enrolment)

**Виз бүхий Түр оршин суугчид NSW мужийн улсын сургуульд хүүхдээ хэрхэн элсүүлэх талаарх хуудсанд зочилно уу:**

<https://www.deinternational.nsw.edu.a/>

**Элсэлтийн талаарх ерөнхий асуулт байвал Боловсролын Яамны төв оффистой дараах утсаар холбогдоно уу: 1300 679 332**

### Орчуулгын Үйлчилгээ

Хэрэв танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 13 14 50 дугаарт залган өөрийн хэлний орчуулагчийг хүсээрэй. Орчуулагч сургууль руу холбогдож таныг сургуулийн ажилтан албан хаагчидтай ярилцахад тань туслах болно. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.